

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/142/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/178
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.ДУЛМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022-02-25 19020345

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,246,058.35	31,374,559.13
33	АВЛАГА	220.00	1,723,633.34
335	Бусад авлага	220.00	1,723,633.34
3351	Байгууллагаас авах авлага		1,723,633.34
3352	Хувь хүмүүсээс авах авлага	220.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	44,245,838.35	29,650,925.79
354	Хангамжийн материал	44,245,838.35	29,650,925.79
35410	Бичиг хэргийн материал	45,300.00	45,300.00
35420	Аж ахуйн материал	38,418,037.35	27,177,319.79
35440	Түлш, шатах тослох материал	838,400.00	838,400.00
35460	Хүнсний материал	4,944,101.00	1,589,906.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	653,934,775.27	591,341,783.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	653,934,775.27	591,341,783.38
392	Биет хөрөнгө	652,854,775.27	590,261,783.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	681,820,962.65	681,820,962.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,126,995.08)	(135,780,870.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,019,440.16	36,969,440.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,601,548.97)	(19,786,983.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,891,670.08	68,888,930.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	(41,995,748.45)	(46,649,628.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,618,309.21	19,618,309.21
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,056,964.33)	(15,737,025.45)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
393	Биет бус хөрөнгө	1,080,000.00	1,080,000.00
39301	Программ хангамж	160,000.00	160,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(160,000.00)	(160,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,080,000.00	1,080,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	698,180,833.62	622,716,342.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.01	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.01	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	698,180,833.61	622,716,342.51
51	Засгийн газрын хувь оролцоо	698,180,833.61	622,716,342.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	91,984,101.50	91,984,101.50
51101	Өмч: - төрийн	91,984,101.50	91,984,101.50
512	Хуримтлагдсан үр дүн	271,423,466.55	195,958,975.45
51210	Өмнөх үеийн үр дүн	344,782,999.90	271,423,466.55
51220	Тайлант үеийн үр дүн	(73,359,533.35)	(75,464,491.10)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	334,773,265.56	334,773,265.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	698,180,833.62	622,716,342.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	614,567,720.99	587,788,476.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	614,567,720.99	587,788,476.84
120	Нийтлэг татварын бус орлого	10,591,220.99	36,040,876.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,591,000.00	28,058,887.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,591,000.00	28,058,887.00
120009	Бусад орлого	220.99	7,981,989.84
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	603,976,500.00	551,747,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	513,924,100.00	465,307,300.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	90,052,400.00	86,440,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	687,927,254.34	663,252,967.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	687,927,254.34	663,252,967.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,673,348.79	589,918,246.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,959,576.41	349,015,697.38
210101	Үндсэн цалин	229,347,396.40	254,059,851.43
210102	Нэмэгдэл	63,385,374.15	59,612,459.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,687,801.80	13,221,949.94
210104	Урамшуулал	32,539,004.06	22,121,437.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,770,431.04	43,549,389.17
210201	Тэтгэврийн даатгал	25,553,462.22	30,374,021.43
210202	Тэтгэмжийн даатгал	1,976,491.55	3,296,187.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,464,633.43	2,636,969.91
210204	Ажилгүйдлийн даатгал	613,139.47	649,535.85
210205	Эрүүл мэндийн даатгал	4,162,704.37	6,592,674.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,260,693.00	73,538,403.87
210301	Гэрэл, цахилгаан	5,135,718.00	3,939,502.37
210302	Түлш, халаалт	71,543,175.00	67,710,501.50
210303	Цэвэр, бохир ус	1,581,800.00	1,888,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,763,435.00	2,185,200.00
210401	Бичиг хэрэг	927,100.00	728,200.00
210402	Тээвэр, шатахуун	723,000.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	96,300.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		225,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,954,035.00	432,000.00
2105	Нормативт зардал	27,092,055.00	13,755,885.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,000.00	74,400.00
210502	Хоол, хүнс	25,155,455.00	11,870,485.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,896,600.00	1,811,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,837,120.00	20,432,869.00
210604	Урсгал засвар	2,837,120.00	20,432,869.00

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	42,000.00	-
210702	Дотоод албан томилолт	42,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	476,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	476,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,472,038.34	87,440,802.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	765,900.00	12,267,550.56
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,496,138.34	75,173,251.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	132,253,905.55	73,334,721.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,135,700.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,135,700.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	116,118,205.55	73,334,721.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	116,118,205.55	73,334,721.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(73,359,533.35)</u>	<u>(75,464,491.11)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(73,359,533.35)</u>	<u>(75,464,491.11)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,984,101.50	334,773,265.56	344,782,999.90	771,540,366.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,984,101.50	334,773,265.56	344,782,999.90	771,540,366.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-73,359,533.35	-73,359,533.35
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,984,101.50	334,773,265.56	271,423,466.55	698,180,833.61
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,984,101.50	334,773,265.56	271,423,466.55	698,180,833.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,984,101.50	334,773,265.56	271,423,466.55	698,180,833.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-75,500,491.11	-75,500,491.11
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,984,101.50	334,773,265.56	195,922,975.44	622,680,342.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	605,274,740.00	575,108,416.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	605,274,740.00	575,108,416.84
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	497,788,400.00	465,307,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	497,788,400.00	465,307,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,433,940.00	23,360,816.84
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,135,700.00	15,378,827.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,298,240.00	7,981,989.84
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,052,400.00	86,440,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,052,400.00	86,440,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	605,274,740.00	575,108,416.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	605,274,740.00	575,108,416.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,020,835.45	501,773,695.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,959,576.41	348,397,985.61
210101	Үндсэн цалин	229,347,396.40	250,943,546.84
210102	Нэмэгдэл	63,385,374.15	59,612,459.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,687,801.80	13,001,233.94
210104	Урамшуулал	32,539,004.06	24,840,745.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,770,431.04	43,317,644.27
210201	Тэтгэврийн даатгал	25,553,462.22	31,117,101.77
210202	Тэтгэмжийн даатгал	1,976,491.55	3,052,210.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,464,633.43	2,441,788.52
210204	Ажилгүйдлийн даатгал	613,139.47	601,822.19
210205	Эрүүл мэндийн даатгал	4,162,704.37	6,104,721.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,776,878.00	73,538,403.87
210301	Гэрэл, цахилгаан	5,610,753.00	3,939,502.37
210302	Түлш, халаалт	63,277,725.00	67,710,501.50
210303	Цэвэр, бохир ус	1,888,400.00	1,888,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,176,400.00	2,991,300.00
210401	Бичиг хэрэг	80,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	160,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	96,300.00	96,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		225,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,777,100.00	2,170,000.00
2105	Нормативт зардал	27,426,550.00	12,867,560.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,000.00	74,400.00
210502	Хоол, хүнс	26,936,550.00	11,089,160.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	1,704,000.00

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	15,878,827.00
210604	Урсгал засвар	500,000.00	15,878,827.00
2107	Томилолт, зочны зардал	104,000.00	-
210702	Дотоод албан томилолт	104,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	720,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	720,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,587,000.00	4,781,975.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,655,000.00	3,143,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,932,000.00	1,638,975.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	132,253,904.55	73,334,721.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,135,700.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,135,700.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	96,014,442.55	73,334,721.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	96,014,442.55	73,334,721.09
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,805,522.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,805,522.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,298,240.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,298,240.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	560,547,300.0	501,773,695.8	58,773,604.3	89.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	560,547,300.0	501,773,695.8	58,773,604.3	89.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	560,547,300.0	501,773,695.8	58,773,604.3	89.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	355,332,400.0	348,397,985.6	6,934,414.4	98.0
210101	Үндсэн цалин	230,516,500.0	250,943,546.8	(20,427,046.8)	108.9
210102	Нэмэгдэл	71,836,800.0	59,612,459.0	12,224,341.0	83.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,200,000.0	13,001,233.9	198,766.1	98.5
210104	Урамшуулал	39,779,100.0	24,840,745.8	14,938,354.2	62.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,969,800.0	43,317,644.3	4,652,155.7	90.3
210201	Тэтгэврийн даатгал	33,756,600.0	31,117,101.8	2,639,498.2	92.2
210202	Тэтгэмжийн даатгал	3,553,300.0	3,052,210.6	501,089.4	85.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,842,700.0	2,441,788.5	400,911.5	85.9
210204	Ажилгүйдлийн даатгал	710,600.0	601,822.2	108,777.8	84.7
210205	Эрүүл мэндийн даатгал	7,106,600.0	6,104,721.2	1,001,878.8	85.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,740,500.0	73,538,403.9	21,202,096.1	77.6
210301	Гэрэл, цахилгаан	9,850,000.0	3,939,502.4	5,910,497.6	40.0
210302	Түлш, халаалт	83,002,100.0	67,710,501.5	15,291,598.5	81.6
210303	Цэвэр, бохир ус	1,888,400.0	1,888,400.0	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,086,300.0	2,991,300.0	95,000.0	96.9
210401	Бичиг хэрэг	100,000.0	100,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	200,000.0	200,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.0	200,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	96,300.0	96,300.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.0	225,000.0	75,000.0	75.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.0	2,170,000.0	20,000.0	99.1
2105	Нормативт зардал	53,820,300.0	12,867,560.0	40,952,740.0	23.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,300.0	74,400.0	5,900.0	92.7
210502	Хоол, хүнс	52,240,000.0	11,089,160.0	41,150,840.0	21.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.0	1,704,000.0	(204,000.0)	113.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.0	15,878,827.0	(15,378,827.0)	3,175.8
210604	Урсгал засвар	500,000.0	15,878,827.0	(15,378,827.0)	3,175.8

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	132,000.0	-	132,000.0	-
210702	Дотоод албан томилолт	132,000.0		132,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,966,000.0	4,781,975.0	184,025.0	96.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,123,000.0	3,143,000.0	(20,000.0)	100.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,843,000.0	1,638,975.0	204,025.0	88.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	560,547,800.0	551,747,600.0	8,800,200.0	98.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	465,307,300.0	465,307,300.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	465,307,300.0	465,307,300.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	95,240,500.0	86,440,300.0	8,800,200.0	90.8
132001	Орон нутгийн төсвөөс	95,240,500.0	86,440,300.0	8,800,200.0	90.8
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30.0	30.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.0	18.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	11.0	11.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,981,989.84	7,981,989.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,981,989.84	7,981,989.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,981,989.84	7,981,989.84
2104	Хангамж, бараа материалын зардал	20,000.00	20,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,000.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,961,989.84	7,961,989.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,961,989.84	7,961,989.84
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,981,989.84	7,981,989.84
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,981,989.84	7,981,989.84
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,981,989.84	7,981,989.84
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө бараа материалыг зөв ангилан бүртгэх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахыг эрхэм зорилгоо болгон анхан шатны боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг юм.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын баг нь 2021 онд дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөө батлан, дотоод хяналтын ажлаа улирал бүр тайлагнан ажилласан.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба

хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 560,547.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,408.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,306.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 560,547.8 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 7,981.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 575,108.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 1,950.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 9,997.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 633.0 мянган төгрөгийн ном, нийт 12,580.3 мянган төгрөгийн

хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр худалдан авсан 633.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 11,100.0 мянган төгрөгийн, дотоод шилжүүлгээр 847.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Бараа материалын дансанд хандиваар 732.8 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 21,874.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 52,172.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,723.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 29,650.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 591,341.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	0.2	1,723.6	1,723.4
Урьдчилгаа			-
Бараа материал	44,245.8	29,650.9	(14,594.9)
Үндсэн хөрөнгө	653,934.8	591,341.8	(62,593.0)
Нийт хөрөнгө	698,180.8	622,716.3	(75,464.5)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	698,180.8	622,716.3	(75,464.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	698,180.8	622,716.3	(75,464.5)

Бараа материалын дансны үлдэгдэл 29,650.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 14,594.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 591,341.8 мянган төгрөг болж 62,593.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 622,716.3 мянган төгрөг болж 75,464.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 560,547.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 560,547.8 мянган төгрөгөөр урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 465,307.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 86,440.3 мянган төгрөгийн, нийт 551,747.6 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 501,773.7 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 58,773.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 501,773.7 мянган төгрөг буюу 89.5 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 7,981.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, бараа үйлчилгээний зардалд 7,981.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 1,950.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 9,997.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 633.0 мянган төгрөгийн ном, нийт 12,580.3 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр худалдан авсан 633.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 11,100.0 мянган төгрөгийн, дотоод шилжүүлгээр 847.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Тус сумын ЕБС-д нярвын үндсэн ажилтай алба хаагч нь тухайн байгууллагад адил төрлийн албан тушаал хавсран гүйцэтгэж байгаа нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д "Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно", мөн хуулийн 28.2-д "Энэ хуулийн 28.1 нь хавсран ажиллахад нэгэн адил хамаарна" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 33 нэр төрлийн 44,001.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 2 нэр төрлийн 160.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 5 нэр төрлийн 839.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тус тус бүртгэлтэй, 2 албан хаагчийн цалинг НДШ төлөлтийн тайланд нийт 1,231.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 127 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 17 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй, 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 29,484.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 20,542.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 79,628.9 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 1,002.9 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 1,185.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 31,208.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 46,232.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 1,002.9 мянган төгрөгийн 3 алдааг залруулав. Үүнд:

1. НДШ төлөлтийн 2021 оны 12 дугаар сарын тайланд 863.7 мянган төгрөгийн илүү төлөлттэй тайлагнасныг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд тайлагнаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,080.0 мянган төгрөгийн газарт тайлант жилд 36.0 мянган төгрөгийн элэгдэл тооцож тайлагнасан нь: УСНББОУС 17-той нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан тайлантай тулган шалгахад нийт хөрөнгийн дүн 103.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 1,185.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд үндсэн ажлаас гадуур давхар хөдөлмөр эрхэлдэг 4 албан хаагчид ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсоны улмаас 734.1 мянган төгрөг, 11 дүгээр сард нийт 26 албан хаагчдад үр дүнгийн урамшуулал тооцон олгоходоо ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсоны улмаас 451.6 мянган төгрөг, нийт 1,185.7 мянган төгрөгийн ХХОАТ-ын дутуу суутган, гарт олгох цалинг илүү олгосон нь: ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт

тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн илүү олгосон цалинг холбогдох албан хаагчдаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар 31,208.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тус сумын ЕБС-д нярвын үндсэн ажилтай алба хаагч нь тухайн байгууллагад адил төрлийн албан тушаал хавсран гүйцэтгэж байгаа нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д "Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно", мөн хуулийн 28.2-д "Энэ хуулийн 28.1 нь хавсран ажиллахад нэгэн адил хамаарна" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд 2 харилцагч байгууллагатай 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 29,484.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны эцэст 1,723.6 мянган төгрөгийн хоолны авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн тайлант онд үүссэн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 33 нэр төрлийн 44,001.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн

нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг цаашид ашиглагдах боломжгүй бол холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд 2 албан хаагчийн цалинг НДШ төлөлтийн тайланд нийт 1,231.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-д "нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтад үндэслэн холбогдох тайлан мэдээг үнэн зөв гаргаж байх

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 5 нэр төрлийн 839.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 273 тоот тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө материалыг зөв ангилан бүртгэж тайлагнаж байх

4. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 2 нэр төрлийн 160.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет бус хөрөнгийг цаашид ашиглагдах боломжгүй бол холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

5. Шилэн данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 127 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 17 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэг	12	79,628.9	3	1,002.9	1	1,185.7	3	31,208.0	5	46,232.3

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn